



I-IX/2022

Тархаасан: 2022 оны 10 дугаар сарын 15




## Улсын хэмжээнд 358.8 мянган толгой мал хорогдсон байна

Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 30.8 сая хээлтэгч малын 25.2 сая (82.0%) нь 2022 оны эхний 9 сард төллөсөн байна. Эм хонины 85.0 хувь, эм ямааны 82.1 хувь, үнээний 72.0 хувь, гүүний 70.3 хувь, ингэний 43.2 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.1 хувь буюу 24.8 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 4.8 (24.0%) саяар өссөн байна.

ЗУРАГ 1. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, хувиар, жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Том малын зүй бус хорогдол 2022 оны эхний 9 сард улсын хэмжээнд 358.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.0 (85.1%) саяар буурсан байна. Малын төрлөөр нь авч үзвэл, хонь 159.8 мянга, ямаа 145.5 мянга, үхэр 32.5 мянга, адуу 20.4 мянга, тэмээ 575-аар хорогдсон байна. Нийт хорогдсон малын 40.5 хувийг ямаа, 44.5 хувийг хонь эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал					Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь				
	2018 I-X	2019 I-X	2020 I-X	2021 I-X	2022 I-X	2018 I-X	2019 I-X	2020 I-X	2021 I-X	2022 I-X
	мянган толгой					хувь				
<b>Дүн</b>	<b>2 216.5</b>	<b>755.8</b>	<b>1 348.0</b>	<b>2 405.4</b>	<b>358.8</b>	<b>3.35</b>	<b>1.14</b>	<b>1.9</b>	<b>3.59</b>	<b>0.53</b>
Адуу	137.3	39.1	69.8	88.2	20.4	3.49	0.99	1.66	2.16	0.47
Үхэр	199	50.3	96.4	146.4	32.5	4.54	1.15	2.03	3.09	0.65
Тэмээ	1.7	1	0.8	15	0.6	0.4	0.22	0.17	3.18	0.13
Хонь	762.8	316.8	675.3	852.3	159.8	2.53	1.04	2.09	2.84	0.51
Ямаа	1 115.5	348.6	505.8	1 303.4	145.4	4.08	1.29	1.73	4.7	0.55

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2022 оны эхний 9 сард Хэнтий аймагт 89.1 (24.8%) мянга, Архангай аймагт 50.3 (14.0%) мянга, Увс аймагт 36.9 (10.3%) мянга, Хөвсгөл аймаг 33.1 (9.2%) мянга, Булган аймагт 23.7 (6.6 хувь) мянган мал хорогдсон нь нийт хорогдлын 65.0 хувийг эзэлж байна.


ЗУРАГ 2. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон 30.8 сая эх малын 104.0 мянга (0.3%) нь 2022 оны эхний 9 сард хорогдсон байна. Хэнтий, Архангай, Төв, Увс, Ховд аймгуудад хээлтэгч мал 5.2-42.3 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 66.0 хувийг эзэлж байна. Харин хээлтүүлэгч малаас ухна 1.7 мянга, хуц 1.7 мянга, бух 648, азарга 323, буур 5 буюу нийт 4.4 мянган мал хорогдсон байна.

Улсын хэмжээнд 2022 оны 9 сард 18.6 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 4.0 (27.0%) мянгаар нэмэгдсэн байна. Харин 2022 оны 7-9 дүгээр сард 5.4 мянган мал өвчнөөр хорогдсон нь эхний 9 сард өвчнөөр хорогдсон малын 29.0 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 91.5 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 3.3 хувь нь аюулт үзэгдлээр, 5.2 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

## Ойлголт, тодорхойлолт

**Том малын зүй бус хорогдол:** Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

## Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь:

Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.



## Эх үүсвэр:

ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2023 оны 01 дүгээр сарын 16

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Д.Намсрайжав  
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212